



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2021 оны 11 сарын 29 өдөр

Дугаар А/560

Алтай хот

┌ Ажлын хэсэг байгуулах тухай ┐

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн 58 дугаар зарлиг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.10.4 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн Үндсэн чиглэлийн 4 дүгээр бүлгийн 4.1.1 дэх зорилт, 2020 оны 11 дүгээр тогтоолоор батлагдсан Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.5.1 дэх зорилтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн Үндсэн чиглэл болон аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан "Газар тариалан, жимс, жимсгэнэ" төсөл болон 108 сая мод тарьж ургуулах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

2. Жил бүр хийгдэх ногоон байгууламж, ойн зурвас, ойжуулалт, модлог ургамлын үр түүж бэлтгэх ажлыг зохион байгуулах, мэргэжил арга зүйгээр хангаж төлөвлөгөөт ажлын явц болон хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Д.Батбилэг)-д даалгасугай.

ОРЛОГЧ



Г.ЧИНБАТ

Аймгийн Засаг даргын 2011 оны
11 дугаар сарын 19-ны өдрийн 11560 дугаар
захирамжийн хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Ажлын хэсгийн ахлагч: Д.Батбилэг - (Аймгийн Засаг даргын зөвлөх)
Гишүүд
- Ж.Бат-Эрдэнэ - (Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн геологи, уул уурхай, байгаль орчин, аялал жуулчлалын бодлого хариуцсан мэргэжилтэн)
 - С.Баярмаа - (Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн хүнс, хөдөө аж ахуйн бодлого хариуцсан мэргэжилтэн)
 - Т.Сүхбаатар - (Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
 - Г.Болдбаатар - (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
 - Д.Алтанзагас - (Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
 - Д.Баттайван - (Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
 - Б.Эрдэнэбаяр - (Сум дундын ойн ангийн дарга)
 - Б.Гайтав - (Хүнс, хөдөө аж ахуйн газрын газар тариалангийн үйлдвэрлэл, технологи хариуцсан мэргэжилтэн)
 - Б.Пүрэвдорж - (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын ой, ургамал байгалийн гамшигийн асуудал хариуцсан мэргэжилтэн)
 - Б.Содмаа - (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын усны нөөц, ашиглалт, хамгаалалт, төрийн бус байгууллага хариуцсан мэргэжилтэн)
 - Г.Болд-Эрдэнэ - (Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын геодези, зураг зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн)
 - Т.Эрхэмбаяр - (Аймгийн "Инноваци судалгаа бизнес хөгжлийн төв" УТҮГ-ын захирал)
 - Ж.Дашдаваа - (Алтай хотын цогц үйлчилгээний газар" УТҮГ-ын дарга)
 - Д.Дамдинпүрэв - (Аймгийн "Инноваци судалгаа бизнес хөгжлийн төв" УТҮГ-ын хөдөө аж ахуй, газар тариалангийн асуудал хариуцсан ажилтан)
 - Ч.Доржсүрэн - (Алтай хотын цогц үйлчилгээний газар" УТҮГ-ын ногоон байгууламж хариуцсан мэргэжилтэн)
 - Ш.Баранчулуун - (профессор, доктор Ph.D) зөвшилцсөнөөр
 - Ж.Очир - (ХААИС-ын багш, доктор Ph.D) (зөвшилцсөнөөр)
 - Х.Лхамноржин - (Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн жимс, жимсгэнэ газар тариалангийн багш) - (Сумдын Засаг дарга нар)
- Нарийн бичгийн дарга: Ж.Мөнхцэцэг - (Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)